





БҮРТГЭЛТЭЙ АЖИЛГҮЙ ИРГЭД, 2021 ОНЫ 2 дугаар сарын эцэст

ᠪᠦᠷᠲᠦᠭᠡᠯᠲᠡᠢ ᠠᠵᠢᠯᠢᠭᠦᠢ ᠶᠢᠷᠭᠡᠳᠦ



Насны бүлгээр



Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд, 2021 оны эхний 2 сард



Шинээр бүртгүүлсэн
ажилгүй иргэд



Бүртгэлтэй ажилгүй
иргэдээс ажилд орсон хүн



2/2021


Тархаасан: 2021 оны 3 дугаар сарын 13



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны захиргааны статистикийн мэдээллээр аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэдийн тоо 2021 оны 2 дугаар сарын эцсийн байдлаар 23.3 мянга болжээ. Үүнээс 15.5 (66.3%) мянга нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 7.8 (33.7%) мянга нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 8.0 (51.6%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Зураг 1. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн иргэд, сараар



Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 5.2 (25.1%) мянган хүн, өмнөх сараас 1.0 (6.1%) мянган хүнээр буурчээ.


Аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2021 оны 2 дугаар сард ажилгүй 3.6 мянган иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 0.3 мянган иргэн ажилд зуучлагдан орж, 4.3 мянган иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан байна. Үүнээс Улаанбаатар хотод 2021 оны 2 дугаар сард нийт 1.2 мянган иргэн нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 56 иргэн ажилд зуучлагдан орсон байна.

Хүснэгт 1. Бүртгэлтэй ажилгүй иргэд, бүс, аймаг, нийслэлээр, сарын эцэст

Аймаг/нийслэл	2018		2019		2020		2021	
	I	II	I	II	I	II	I	II
Дүн	24 244	24 588	24 404	24 023	20 612	20 643	16 472	15 462
Баруун бүс	4 564	4 786	4 393	4 273	3 657	3 824	3 772	3 664
Баян-Өлгий	844	997	1 103	1 011	719	983	836	711
Говь-Алтай	738	549	741	673	470	548	652	653
Завхан	1 044	1 126	754	741	582	545	683	649
Увс	674	897	710	794	863	723	825	799
Ховд	1 264	1 217	1 085	1 054	1 023	1 025	776	852
Хангайн бүс	4 894	4 604	5 467	6 195	4 631	4 570	4 964	4 344
Архангай	725	770	794	827	689	687	715	823
Баянхонгор	860	619	1 082	1 036	678	609	838	695
Булган	705	673	1 082	1 067	723	691	677	433
Орхон	1 134	1 034	918	1 003	927	901	1 243	1 259
Өвөрхангай	987	1 149	893	1 570	1 180	1 232	1 092	913
Хөвсгөл	483	359	698	692	434	450	399	221
Төвийн бүс	5 109	4 840	3 992	3 436	3 181	3 176	2 427	2 586
Говьсүмбэр	292	200	149	146	284	264	67	82
Дархан-Уул	1 838	1 717	1 316	1 337	1 147	1 077	881	893
Дорноговь	915	926	865	536	226	298	216	221
Дундговь	583	486	407	347	347	403	366	382
Өмнөговь	416	233	238	246	372	392	303	300
Сэлэнгэ	676	743	629	553	434	418	169	329
Төв	389	535	388	271	371	324	425	379
Зүүн бүс	2 489	2 734	2 328	2 484	2 281	2 409	1 561	1 545
Дорнод	1 113	1 142	1 155	1 219	1 194	1 246	713	671
Сүхбаатар	960	993	574	647	728	720	399	455
Хэнтий	416	599	599	618	359	443	449	419
Улаанбаатар	7 188	7 624	8 224	7 635	6 862	6 664	3 748	3 323

Улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 881 (19.7%) хүн, ажилд зуучлагдан орсон иргэд 402 (56.7%) хүнээр буурч, ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 562 (15.1%) хүнээр нэмэгджээ. Харин өмнөх сараас шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд 932 (20.6%) хүн, ажилд зуучлагдан орсон иргэд 404 (56.8%) хүн, ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагдсан иргэд 1.1 (21.1%) мянган хүнээр тус тус буурчээ.

Зураг 2. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн, ажилд зуучлагдан орсон иргэд, аймгаар, 2021 оны 2 дугаар сарын эцэст




Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад 2021 оны 2 дугаар сард 3.6 мянган хүн шинээр бүртгүүлсний 877 (24.5%) нь ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан иргэд байгаа нь өмнөх сараас 186 (26.9%) хүнээр өсжээ.

Зураг 3. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад шинээр бүртгүүлсэн ажилгүй иргэд, ажилгүй байгаа шалтгаан, дүнд эзлэх хувиар, 2021 оны 2 дугаар сарын эцэст




Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 243 (1.6%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа бөгөөд 123 (50.6%) нь эмэгтэйчүүд байна.

Зураг 4. Хөгжлийн бэрхшээлтэй бүртгэлтэй ажилгүй иргэд, аймаг, нийслэлээр, 2021 оны 2 дугаар сарын эцэст




Бүртгэлтэй ажилгүй хоёр хүн тутмын нэг нь бүрэн дунд, гурван хүн тутмын нэг нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой байна.

Зураг 5. Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшин, хүйс, дүнд эзлэх хувиар, 2021 оны 2 дугаар сарын эцэст



Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 52.4 хувийг 15-34 насны залуучууд эзэлж, энэ үзүүлэлт Төв, Дундговь, Говь-Алтай, Дархан-Уул, Архангай, Говьсүмбэр, Булган, Завхан аймаг болон Улаанбаатар хотод улсын дунджаас 0.7-10.1 пунктээр доогуур байна.

Зураг 6. Бүртгэлтэй ажилгүй иргэд, насны бүлэг, хүйс, дүнд эзлэх хувиар, 2021 оны 2 дугаар сарын эцэст



Ойлголт, тодорхойлолт:

- **Ажил хайгч иргэн:** Ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцөлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг ойлгоно.
- **Бүртгэлтэй ажилгүй иргэд** гэж цалин хөлс, орлого олох зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийн байгууллагад ажил хайж бүртгүүлсэн болон цалин хөлстэй ажил эсвэл хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлэхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй хүн юм.

Эх үүсвэр: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Мэдээлэл авах линк:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>



Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 4 дүгээр сарын 18

*Хүн ам, нийгмийн статистикийн газрын
статистикч Н.Болорчимэг
Утас : (976-51)-265543*

*Хүн ам, нийгмийн статистикийн
газрын дарга А.Амарбал
Утас : (976-51)-264805*

